



DEFENSE RESEARCH
INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.01.017>

The System and Operations of the Yuan Dynasty's Station

Togtuun Erdenekhishig

*Ph.D., Professor, Leading research fellow, Center for military history studies,
Defense Research Institute of Mongolia*

E-mail address: khishig_39@yahoo.com, ORCID: 0009-0007-2972-954X

Received: 05 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 24 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

After Kublai Khan unified the Southern Song dynasty, it became a natural and necessary task to establish a transportation and communications network, including a the horse relay system, that could reach every corner of the vast territory of the Yuan dynasty. Accordingly, Kublai Khan improved roads and routes and further perfected, reformed, and developed the postal relay service.

After ascending the throne, Kublai Khan, in addition to the existing the horse relay system, established a rapid relay (express courier) system.

During the Yuan dynasty, transportation and communication routes linking Daidu, Shangdu, Karakorum, and other distant settlements expanded and developed on an unprecedented scale. Moreover, routes connecting Central Asia and Europe linked the East and the West.

In the Yuan dynasty, the horse relay system service was administered by a dedicated government office with established rules and regulations. Couriers, envoys, officials traveling through the relay stations, as well as relay households, were provided with food, lamp oil, firewood, and fuel.

By creating a highly organized the horse relay system that connected the four directions and the eight corners of the realm, transmitted imperial edicts, and ensured the safety of envoys, tax collectors, merchants, military personnel, and religious clergy, Kublai Khan of the Yuan dynasty made an enormous contribution to the development of transportation and communications not only in Mongolia and China, but also in the world at large.

Keywords: Yuan dynasty, Kublai Khan, Southern Song dynasty, transportation and communications, the horse relay system, postal service, postal officials.

Юань улсын өртөөний тогтолцоо, үйл ажиллагаа

Тогтуун Эрдэнэхишиг

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын
төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Ph.D), профессор*

khishig_39@yahoo.com, ORCID: 0009-0007-2972-954X

ХУРААНГУЙ

Хубилай хаан Өмнөд Сүн улсыг нэгтгэсний дараа Юань улсын өргөн уудам нутаг дэвсгэрийн өнцөг булан бүрт хүрэх зам харилцаа, улаа өртөөний тогтолцоог байгуулах шаардлага зүй

ёсоор тавигдсан юм. Тиймээс Хубилай хаан зам харилцааг сайжруулж, өртөөний албыг улам бүр төгөлдөржүүлэн, шинэчлэн зохион байгуулж хөгжүүлжээ.

Хубилай хаан ширээнд суусны дараа урьд байсан өртөөний тогтолцооноос гадна шуурхай өртөөний систем байгуулжээ.

Юань улсын үед Дайду, Шанду, Хархорин болон бусад алс холын суурин газруудыг холбосон зам харилцаа урьд өмнө байгаагүйгээр өргөжин хөгжсөн төдийгүй Дундад Ази, Европыг холбосон зам нь өрнө дорныг холбож байв.

Юань улсын үед өртөөний алба хариуцсан яамтай, дүрэм журамтай, өртөөгөөр дамжин өнгөрч буй улаач, элч, түшмэл болон өртөөний өрхийг хоол хүнс, дэнгийн тос, түлээ түлш зэргээр хангадаг байсан байна.

Юань улсын Хубилай хаан дөрвөн зүг, найман зовхисыг холбосон, хааны зарлигыг уламжилж буй элч, алба татвар хураагч, худалдаачин, цэргийнхэн, шашны лам хувраг нарын аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан, өндөр зохион байгуулалттай өртөөний тогтолцоог бий болгож чадсанаараа Монгол, Хятадын төдийгүй дэлхийн зам харилцааны хөгжилд асар их хувь нэмэр оруулсан юм.

Түлхүүр үг: *Юань улс, Хубилай хаан, Өмнөд Сүн улс, зам харилцаа, өртөө, өртөөний алба, өртөөний түшмэл*

Оршил

Төр улс гэж үүсэн бий болсон цагаас тухайн улсын дээшлэн дэвжих бууран доройтоход чухал нөлөө үзүүлж байсан олон хүчин зүйлийн нэг нь тухайн үеийн өртөө** буюу өнөөгийн хэллэгээр мэдээллийн хэрэгсэл байсан юм.

Хүннү нар эдүгээгээс 2000 гаруй жилийн тэртээ Ази, Европыг холбосон хүчирхэг гүрэн байгуулахад элч, улаачийн гүйцэтгэсэн үүрэг асар их байсан нь ойлгомжтой. Хүннүгийн элч нар харь оронд зорчихдоо шаньюйн гэрэгэтэй явдаг байв. НТӨ II зууны үед хүннүгийн элч баруун хязгаарын орноор явахдаа шаньюйн гэрэгэтэй байжээ. Хүннү элч бүр сүүлд НТ 25 онд Хятадад мөн л гэрэгэтэй зорчиж байсан байна (*Т.Эрдэнэхишиг 2008, х. 132*). Тухайн үед төрийн хэргээр зорчигчид зам явах үнэмлэхийн чанартай жижиг, том болон төмөрлөг, модоор хийсэн янз бүрийн гэрэгэ хэрэглэж байжээ. Хүннүгийн үед хаад ноёдын эрх ямбыг баталгаажуулсан тусгай чулуун гэрэгэнүүдийг ч хэрэглэдэг байсан байна. Тийм гэрэгэний онцлог нь 11,8х6,8 см-ийн (0,8-1 см зузаан) хэмжээтэй, дөрвөн булан, голдоо 4 чон чулуун шигтгээтэй, дөрвөн хажууд чандмалсан гурав, гурав, нэг өнцгөөс нөгөөг хүртэл үржих тэмдэг шиг солбицуулан шигтгэсэн 31 оюу шигтгээтэй, оосорлон зүүх нүх нь нэг талдаа хоёр дүгрэг, нөгөө талдаа нэг зууван хэлбэртэйгээр гаргасан хар чулуун зүүлт юм (*Ж.Базарсүрэн 2006, х. 33*).

Хүннүд мэдээлэл хурдан шуурхай дамждаг байсны тод жишээ бол Хүннүгийн хил хязгаарт дайсан этгээд довтлоход шаньюй тэргүүтэй ихэс дээдэс удалгүй мэдэж үгэр түргэн хариу үйлдэл хийж ард иргэдээ нутгийн гүн рүү нүүлгэн хамгаалж чаддаг байсан явдал юм.

Хожмын нүүдэлчдийн төр, улсууд зам харилцааны энэ уламжлалыг залгамжлан хөгжүүлсээр Их Монгол улсын үед хүргэсэн бөгөөд XIII зууны үеийн монголчууд дэлхийд анх удаа өртөөг зам тээвэр, харилцаа холбооны цогц сүлжээ

* Албаны хүмүүс албан зар, бичиг зэргийг дамжуулах, өнгөрүүлэх, хүргэх морин хөсөгтэй буудлын газар. Өртөөг дунджаар 30 км тутамд байгуулдаг байсан гэдэг нь өртөө бол байришил эзэлсэн объект - байгууллага болохыг илэрхийлдэг. Нөгөө талаас өртөө нь нарийн зохион байгуулалттай, цэрэгжилтийн байдалтай, элч төлөөлөгчдийн аюулгүй байдал, тав тухыг хангах, морь унааг сэлбэх, газарчлах, амраах, хооллож ундлах, зар мэдээ, шуудан, тушаал дамжуулах үүрэгтэй байсан гэдэг утгаараа нэгэн төрлийн төрийн алба байсан гэж хэлж болно..

болгон зохион байгуулж дэлхийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд хэрэглэсэн байна.

Зорилго, зорилт: Юань улсын үеийн өртөөний түүхийг улируулан судалж, үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино. Энэ зорилгын хүрээнд эртний хятадын түүхийн эх сурвалж, дотоод, гадаадын судлаачдын судалгааны зохиолын мэдээ сэлтийг, харьцуулан судалж тодотгон тодруулах, Юань улсын өртөөний түүхийг эртний түүхэн эх сурвалжуудын мэдээнд тулгуурлан судалж үнэлэлт, дүгнэлт өгөх зорилт тавьсан болно.

Судалгааг явуулсан арга зүй: Задлан шинжлэх нэгтгэн дүгнэх, Баримт бичгийн (эх сурвалжийн) шинжилгээ, Герменевтик ба тайлбар зүйн арга,

Үндсэн хэсэг

Их Монгол улсын үед байгуулагдсан өртөөний тогтолцоо нь Юань улсын үед илүү сайжран хөгжсөн бөгөөд ялангуяа Өмнөд Сүн улсыг мөхөөж бүх хятадыг нэгтгэсний дараа асар өргөн уудам нутаг дэвсгэрийг эзэмшин захирах болсон тул тэдгээрийг хооронд нь холбосон зам харилцаа, улаа өртөөний бүхэл бүтэн тогтолцоог бий болгох шаардлагатай болжээ. Тиймээс Юань улсын үед ус, хуурай зам хосолсон тээврийн ажил урьд өмнө байгаагүйгээр өрнөн хөгжиж, их бага өртөө зам аалзны тор мэт хэрэн сүлжсэн байв (*Г.Алтансүх, et al. 2025, тал 17*).

Хубилай бүх Хятадыг нэгтгэсний дараа Дадуг нийслэл болгож син шэнь** бүхэнд хүрэх өртөө байгуулжээ. Нийт улс даяар 1500 гаруй өртөө (тухайн үед улаачийн газар хэмээн нэрлэгдэж байсан) байгуулсан ба Юань улсын өртөө нь дорно зүгт Солонгос, зүүн хойд зүгт Нурган, хойд зүгт Киргиз, баруун зүгт Эл хаант, Цагаадай болон Алтан ордны хаант улсаар дамжин европын улс орнууд, баруун өмнө зүгт Төвд, өмнө зүгт Аннам, Бирм хүрч байсан байна (*史卫民, 中国军事通史第十四卷-元代军事史 1998, 第371 页*).

Өртөө зам дотроос их нийслэл Дайду ба дээд нийслэл Шандуг холбосон өртөө зам нь маш чухал үүрэг гүйцэтгэж байв. Тухайн үед Шанду хот нь нүүдлийн ба суурин соёл иргэншлийн уялдаа холбоос байсан бөгөөд мөн өмнө умрыг нэгтгэн захирах улс төрийн төв болж, Ази Европыг холбох зам харилцааны чухал зангилаа хотын нэг болж байсан байна. Тухайн үед дээд нийслэл Шанду-Их нийслэл Дайду (Бээжин) –г холбож байсан өртөөний зам дөрвөн зурвас байв. Үүнд:

Шандугаас Дайду хүрэх өртөө зам-Энэ нь хаан эзний “нянь” тэргээр залрах чухал өртөө зам болно. Түүний аялалын шугам ба өртөөний нэрсийг жагсаавал Шанду-Хуаньжоу өртөө, Лилинтай өртөө (Бор хот), Цагаан нуур нүүдэл ордон, Мянган өртөө, Шаварт өртөө, Өрөөсөн чулуу хаалга өртөө, Цичэн өртөө, Лунмэнь өртөө, Дяово өртөө, Юйлинь өртөө, Цзиньшань өртөө, Цзюйюнгуань боомт

** 行省-засаг захиргааны нэгжийн нэр. Юань улсын Хубилай хаан жиюаны 16 он буюу 1279 онд өмнөд Сүн улсыг мөхөөж бүх хятадыг нэгтгэсэн билээ. Хил хязгаар, нутаг дэвсгэрийн хэмжээ Хан, Тан зэрэг улсын үеийнхээс ч хавьгүй өргөн уудам болсон байв. Юань улсын төв засгийн газар төвлөн засах яамнаас Шандун, Шаньси болон Хэбэй гэх гурван газрыг дотор газрын гадаад бүс болгож эдгээрээс бусад нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгжид хуваан, төвлөн засах яамны байгуулсан Сингийн төвлөн засах газар (行中书省) -ыг байгуулсан ба Сингийн төвлөн засах газрыг товчоор син шэнь буюу шэнь хэмээн нэрлэж, түүнээс доош чөлгө (路), шилтгээн (府), жөү (州), шиан (县) зэрэг засаг захиргааны нэгж байгуулжээ. Юань улс Линбэй (岭北), Ляо Янь (辽阳), Хөнань (河南), Шанси (陕西), Сычуань (四川), Гансу (甘肃), Юньнань (云南), Жяньжө (江浙), Жяньси (江西), Хугуан (湖广) зэрэг арван газарт сингийн төвлөн засах газар байгуулжээ

Бэйкоу, Нанькоу, Чанпин өртөөг дамжиж Дайдуд хүрнэ. Аялалын зам нь 375 км, 18 өргөөтэй, 24 өдрийн замыг хөөдөг байна.

Дайдугаас Шанду хүрэх Хар хөндийн зам-Энэ бол мөн эзэн хааны залардаг жинхэнэ өртөө зам болно. Энэхүү замаар хаан эзнийг бараадан төрийн түшмэл, шадар хэшигтэн, бичиг цэргийн сайд, түшмэл нар аялдаг байв. Аялалын шугам нь Бээжин, Чанпин хүйс өртөө, Лунмэнь өртөө, Хар хөндийн зам, Шаваргайн өртөө, Хөлнуурын өртөө, Цагаан нуур нүүдэл өртөө, Лилинтай өртөө, Хуаньчжоу өртөөг дамжиж дээд нийслэл Шандуд хүрдэг. Замын бүх өртөө нь 610 гаруй км, сар илүү аялдаг байна.

Дайдугаас Шанду хүрэх баруун зам-Энэ бол элч, сайд, ноёд түшмэдийн аялан явдаг өртөө зам болно. Аялалын шугам нь Дакоу, Хуанькоу дянь, Лунхутай, Манчуургын уул, Хуайлай сянь, Тунму дянь, Цзунцзюй, Фэнлэ, Цзимин шань, Сюаньтяо-эр, Люйши, Лиди, Наньпо дянь зэрэг 24 өртөөг өнгөрч 550 км аялж Шандун хүрдэг байв.

Шандугаас Дайду хүрэх зүүн зам – энэ замаар Юань улсын шадар түшмэд, байцаагч ноён, элч нар үргэлж аялдаг байжээ. Аялалын шугам нь Шанду, Зүүн сэрүүн ордон (Цагаан хот), Дахэ-эр, Фэньшан-жи, Сюаньиньжоу Губэй коу, Таньжоу, Шуньжоу, Тунжоу- аар дамжиж Бээжин хүрдэг. Аялалын замын бүх урт нь 650 гаруй км, сар илүү аялан Дайду хүрдэг байжээ.

Юань улсын үед Давааны ард нэвтрэх тэргэн зам, морин зам, нарийн зам гэх нийт 119 өртөө байгуулж, Дайду (Бээжин), Дээд нийслэл Шанду, Их Монгол улсы нийслэл Хархорумыг нэгэн шугамаар холбосон байна. Юань улсын үед Дайдугаас Монголын төв нутагт нэвтрэх өртөө зам гурван чиглэлтэй байв (*Г.Алтансүх, et al. 2025, тал 17*).

Юань улсын үед хуурай болон усан замын гэх хоёр төрлийн өртөө байв. Хуурай замын өртөө нь морь, үхэр, тэрэг, илжиг луус зэрэг ердийн хөсөг хэрэглэдэг байсан бол усан замын өртөө нь завь хэрэглэдэг байжээ. Жяньжө, Жяньси, Хугуан зэрэг мужид тодорхой тооны усан зогсоол байсан ба зогсоол бүрт ойролцоогоор 20 орчим завь байжээ (*中国丝绸之路辞典 1994, 第32 页*). Энэ тухай Юань улсын сурвалжид: “Юань улсын хуулиар замчин гэдэг нь өртөөлөн дамжуулахын орчуулсан нэр болой. Өртөө нь хил хязгаарын хэрэг учрыг дамжуулан, цааз зарлигийг тархаах болой. Эртний хүний өгүүлснээр цааз зарлигийг өртөөлөн уламжилдаг бөгөөд үүнээс хүнд нь үгүй болой. Аливаа өртөө нь хуурайд морь, үхэр, илжиг эсвэл тэрэг хэрэглэнэ. Усанд онгоц хэрэглэнэ” (*宋濂. 赵坝. 王祎 1976*) хэмээн бичсэн байдаг.

Тухайн үед өртөөнд морь, үхэр илжиг хэрэглэхээс гадна мөн Ляодун зэрэг газарт чарганд нохой хөллөн өртөөний албыг залгуулдаг байв. Жишээ нь: Ляоянь (辽阳) –д нийт 15 нохойг өртөөнд 218 нохой байсан байна (*中国丝绸之路辞典 1994, 第32 页*).

Өртөөний бошго түшмэлийг “Төрийн хэрэг захиран шийтгэх яам” болон “Цэргийн явдлын яам”-наас хавсран томилох ба өртөөний албыг засгийн газраас томилсон өртөөний өрх хариуцан залгуулж, өртөөнд хэрэглэх морь, үхэр, тэрэг, завь зэргээр хангаж, усчин агтчин нарт хариуцуулж, өртөөгөөр дамжин өнгөрч буй элчийг хоол хүнс, дэнгийн тос, түлээ түлш зэргээр хангадаг байв. Монголын

олон овог болон хятадын жоу сяньд дээрээс томилсон өрхүүд өртөөний албанд зүтгэх ба “Хойд зүгийн өртөөний өрхөөр өсөх мал олонтой айлыг сонгож, өмнө зүгийн өртөөний албанд зүтгэх өрхөөр тариалах газрын хэмжээг харгалзан сонгодог байв. Нийт улсын хэмжээний 1500 гаруй өртөөний тасралтгүй шуурхай байдлыг хангахын тулд Юань улсын засгаас баталсан 30 түм гаруй өрх өртөөний албанд зүтгэж байв (史卫民, 中国军事通史第十四卷-元代军事史 1998, 第371-372 页) Юань улсын өртөө ихэд өргөжин тэлж, хөгжсөн тухай Юань улсын сударт: “Дөрвөн зүгийн ирэх одох элч нар буухад гэр буй, ундаасах аваас гэр болоод идээ ундаа буй. Хуурай, усан замуудыг холбосноор юань улс тэнгэрийн дор сүр жавхлангаараа урьд үеэс давжээ. Эдүгээ өртөө засаг ихийг үүсгэж, олон мужийн усан, хуурай замын тоог тэмдэглэж, Ляодунгийн нохойн өртөөг мөн хавсран байгуулав” (王祎 1976) гэж бичжээ.

Юань улсын үед өртөөний албанд зүтгэж байсан өрхөд татварын хэмжээг бууруулан тогтоодог байсан байна. Тухайлбал, Жи юаний тэргүүн оны хаврын эхэн сарын харагчин туулай өдөр (1264 оны хоёрдугаар сарын 26) зарлигаар олон вангийн харьяаны гар урчууд иргэний дансанд орсон байх юм бол алба, гувчуурыг бүрэн авагтун, күнзийн сурталтан, бүддийн лам, бомбо е-ли-кэ-вэнь (эрхүүд-эркэун гэдэг монгол үгийг хятадаар галигласан нэр, энэ нь христос шашны лам), да ши минь (персийн даншиманд гэдэг үгийг хятадаар галигласан нэр, энэ нь мусульманы лам) зэрэг урьд хэлтрүүлсэн өрхөөс эдүүгээ уг газрын татвар, худалдааны татварыг бүрэн авагтун, монгол, хятад цэргийн өртөөний өрхөөс авах газрын татварын хагасыг хорогдуулагтун (Г.Сүхбаатар 1968) гэжээ.

Өртөө хариуцсан яамнаас жил бүр өртөөч нарын хоол хүнс, эд хэрэгсэл, цалин пүнлүү болон морь малд өгөх өвс тэжээлийн норм хэмжээг тогтоож өгдөг байв. Тухайлбал, Тайзуны анхдугаар оны 11 дүгээр сард зарлигаар олон үхэр, дэвсгэр морины өртөөний 100 өрх бүр хятад тэрэг арвыг өгчээ. Өртөө бүрт амуу будааны сан хөмрөг байгуулан, өртөөний өрхөд жил бүр нэг пайгийн дотроос нэг таар бариулан зуун өрхийг нэг хүнээр захируулсан ба умар зүгийн элч, түшмэдэд өдөр бүр мах нэг жин, гурил нэг жин, амуу нэг шөн /升/, архи нэг пин олгодог байв. 4 дүгээр оны 5 дугаар сард зам дагуух түшмэд ба жич өртөөч нарт зарлиг буулгасан нь: “Элч түшмэл бичиггүй пай авч өртөөч нарт морь өгсөн өртөөний түшмэл болон томилогдсон олон түшмэлтэй ял хэлэлцэнэ. Бичиг пай /牌照/ байсаар атал өртөөний морь өгөхгүй болбоос мөн ял хэлэлцэнэ. Цэргийн яаралтай хэрэг явдлын үед яаралтай будаг, утас, архи, амуу, торго, харцгай болон хаан, вангуудын хэрэглэдэг тусгай олон зүйлийн эд хэрэглэл зэргийг хэдий фай бичиггүй боловч мөнхүү тоог үзэж үхэр тэрэг нийлүүлэн өгөгтүн” хэмээжээ.

Шызу Жунтун /世祖中统/-ий 4 дүгээр оны 3 дугаар сард Жун шу шөн /Төвлөн засах яам-中书省/-д хэлэлцэж өртөөний морь унах түшмэл, хол морьтой аялах элч, түшмэл, тэднийг дагалдан явах хүмүүс болон бичиг хүргэх Гүн ү юань же /公务员解/ нарт оногдох хувийг тогтоожээ. Үүнд: Өртөөгөөр явж буй элч, түшмэл морь сэлгэх газарт элч, түшмэлд шингэн будаа өгч ундаасваас архи өгч, дагалцах хүнд шингэн будаа, хоноглох газарт элчид цагаан амуу нэг шөн, гурил нэг жин, архи нэг шөн, тос, давс, зоос арвыг өгдөг байв. Өвлийн эхэн сарын нэгнээс эхэлж өдөр бүр нүүрс 5 жин өгөх ба үүнийг 10 дугаар сарын нэгнээс эхэлж цагаан сарын 30-ны өдөр зогсооно. Дагалдан яваа хүнд цагаан амуу нэг шөн, гурил нэг жин өгөх ба

өвлийн сарын шинийн нэгнээс эхэлж өдөр бүр нүүрс 5 жин өгнө. Энэ нь 10 дугаар сарын нэгнээс эхэлж цагаан сарын эцэст зогсоно. Дагалдан яваа хүнд цагаан амуу нэг шөн, гурил нэг жин өгнө. Хол замд явах морьтой элчин түшмэл зарлиг бичиг, зар хүргэх төрийн түшмэлээс нэгээс хоёр ахлах түшмэл (эрх мэдэл байр суурь нь илүү) хоноход тогтоосон хувь дүрмээр өгч дараагийн хүнд шингэн будаа өгч 1 моринд өвс 12 жин, тэжээл 5 шөн өгнө. 10 сараас эхэлж 3 дугаар сарын 30 хүрч зогсоно. Цагаан амуу нэг шөн, гурил нэг жин, тос давс бага сага хэрэглэлд зоос өгдөг байв (宋濂. 赵坝. 王祚 1976).

5 дугаар сард Юньжөү /云州/-д өртөө байгуулж. Нань жөү (南州)-ийн хавийн өртөөний өрхийн данснаас дээд өрхийн морин өртөө хааж чадахыг нь сонгож морь нэг, үхрийн өртөө үхэр хоёрыг авч олон өрхөөс өртөөний алба хааж чадахыг нь сонгож, өөрөөс нь асуулгүй өрх бүр хоёр эр гаргаж, гэрийн хамтаар өртөөний газарт харьяалагдан нүүн очиж байрладаг байлаа.

Өртөөний өрхөөс өртөөч дутах, ядарч оргож босох аваас тухай бүрт нь байцаан нөхөж, нэмэлт нөхөн төлбөр авдаг байв. (юань улсын үед өртөөний өрхийн хүн нас барах, оргох зугтах тохиолдол гарч хүн дутвал түшмэлийн алба тогтсон хугацаанд нөхөн хангалт хийж, хангалт олгодог байлаа (宋濂. 赵坝. 王祚 1976).

Жиюаны 7-р он буюу 1270 оны 11-р сард нийт өртөөний албыг хариуцан захирах газрыг төвөөс байгуулжээ. 13 онд өртөө хариуцсан газрыг (都统领使司) харилцааны яам (通政院) болгон өөрчилжээ. Жидагийн 4-р он буюу 1311 оны 3, 4-р сард харилцаа холбооны яам өртөөний албыг төвлөн засах яамны цэргийн хэлтэст шилжүүлэн өгчээ. Долдугаар сард харилцааны яам нь монгол дахь өртөөг хариуцуулж, цэргийн хэлтэс нь хятад газрын өртөөг хариуцах болжээ. Янь Ёугийн 7-р он буюу 1320 оны 4-р сард монгол, хятад өртөөг “Шизугийн урьдын ёс дүрмийг дагаж, харилцааны яаманд бүгдийг нь буцаан шилжүүлжээ (史卫民. 中国军事通史. 第十四卷-元代军事史 1998, 第373 页). Энэ тухай сурвалжид: “Анханд өртөөг цэргийн явдлын яаманд хавсруулсныг хойно засгийг нэвтрүүлэх яаманд харьяатуулжээ. Эдүгээ засгийг нэвтрүүлэх яам тэгшлэн засахыг осолдуулан, өртөө доройтож ядарсан тулд хуучин ёсоор цэргийн явдлын яаманд тушааж захируулбаас зохимуй хэмээснийг зарлиг ёсоор болгожээ” (王祚 1976) хэмээн бичсэн байна. Энэ мэдээнээс харахад өртөөний асуудалд хаан ихээхэн анхаарал хандуулдаг тул алдаа дутагдлыг цаг алдалгүй засаж байжээ.

Юань улсын үед өртөөний асуудал хариуцсан түшмэд байсан талаар Юань улсын сударт: “Дотоодод болбоос тэнгэрийн фү хариуцна. Гадаадад болбоос улсын түшмэл хариуцна. Өртөөний хариуцсан түшмэл буй. Тилин түшмэл буй. Боомт, хурлын газарт байцааж тодруулах түшмэл (脱脱禾孙todquyulsun) томилж, байцаан асуухыг эрхэлнэ. Бүгд (түшмэд) засгийг нэвтрүүлэх яам, төвлөн засах яаманд захирагдана” (宋濂. 赵坝. 王祚 1976) гэжээ.

Ти лин түшмэлийг албан яамнаас сонгон томилох ба фү ши, байхуг өртөө дотроосоо томилно. Дадү, Шандугийн хоорондох өртөөгөөр жил бүр хааны хөсөг тэрэг, түшмэл ноёд нааш цааш олонтоо ирж очих, улаач олон солигддог зэрэг нь гадаад жүнтэй адилгүй учраас дээрх хүмүүсээс гадна өртөөний ахлагч болон өртөөч нарыг нэмж томилж байжээ. Өртөөгөөр “Засгийн тогтоол шийдвэрийг зарлан тунхаглах, цэргийн яаралтай мэдээ дамжуулдаг” байсан учраас хааны

ордны цэргийн яаралтай шуурхай албан хэргээс бусад үед өртөөний агтыг дураар хэрэглэхийг хориглодог” байжээ.

Юань улсын үед гэрэгэ олгодог тусгай газар байсан ба “Алтан тэмдэг”, “Шар алтан тэмдэг”, “Мөнгөн тэмдэг”, “Мөнгөн үсэгт дуут тэмдэг”, “Мөнгөн хөх тэмдэг”, “Гэрэлтэй сувдат барс тэмдэг”, “Гүмбараа матар барс тэмдэг”, “Монгол үсгийн (дөрвөлжин үсгийн) барс тэмдэг”, “Далай хөх тэмдэг”, “Өршөөл тэмдэг” зэрэг олон төрлийн тэмдэг, гэрэгэ бий болгосон байна (*Ч.Арьяасүрэн 1992, тал. 51-52*). Өртөөгөөр дамжин өнгөрч буй хүмүүс албан яамны гэрэгэтэй байх ёстой байв. Улс орны цэргийн их хэрэг, хааны зарлигийг дамжуулж буй элч өртөөгөөр зорчихдоо дугуй хэлбэртэй алтан үсэгтэй гэрэгэ үзүүлнэ. Харин ван ноёд, хааны хүргэн, гүнж нар мөн түүнчлэн цэргийн яаралтай чухал үүрэг даалгавар хүлээсэн элч нар дугуй хэлбэртэй мөнгөн пайз хэрэглэдэг байв. Цэргийн хэрэгт хэрэглэдэг алт, мөнгөн үсэгтэй дугуй тэмдгийг бас дугуй пайз гэж нэрлэнэ (*史卫民, 中国军事通史. 第十四卷-元代军事史 1998, 第372 页*).

Энэ тухай сурвалжид: “Өртөөнд хааны тамгатай бичгийг өгөхийг нь дэвсгэр пү /鋪/ морины зарлиг хэмээмүй. Цэргийн чухал яаралтай хэрэг тохиолдох аваас алтан үсэгт дүгрэг тэмдгийг хэрэглэмүй. Мөнгө үсэг болбоос удаах нөхцөлд хэрэглэнэ” (*宋濂. 赵坝. 王祎 1976*) хэмээн бичсэн байдаг.

Дугуй пайзтай хүн өртөө бүхэнд хоол хүнс болон өртөөний морь, үхэр тэргээр хангагдана. Хэдийгээр засгаас тогтоосноор бол өртөөнийхөн юун түрүүнд цэргийн хэрэгцээг хангах ёстой боловч шат шатны түшмэл ноёд, язгууртнууд болон дээд зиндааны лам хувраг зэрэг хүмүүс аль болохоор амар дөхөм өртөөний системийг ашиглан зорчихыг хүсдэг байснаас өртөөнд хүндрэл бэрхшээл учруулж, зарим үед цэргийн шуурхай мэдээ дамжуулахад хүртэл саад учруулах хэмжээнд хүрсэн байна.

Шуурхай өртөө. Хубилай хаан ширээнд суусны дараа урьд байсан өртөөний тогтолцооноос гадна шуурхай өртөөний систем байгуулжээ. Жунтуны анхдугаар он буюу 1260 оны 4-р сард Яньжин болон Кайпин хотын хооронд мөн Кайпин Жинбэйгийн хооронд шуурхай өртөө байгуулж улмаар жил ирэх бүр өөр бусад газарт нэмж байгуулсаар “10 ли*, 15 ли, 25 ли газар нэг шуурхай өртөөтэй болж чадсан байна. Арван өртөөнд нэг дарга томилж, нэг өртөөнд 5 хүн суулгадаг бөгөөд зарим үед 15 хүн ч байдаг байв. Дадуд шуурхай өртөөний ерөнхий захиргааны газрыг байгуулж өртөөний хэргийг эрхлүүлдэг байв. Шуурхай өртөө бүхэн харьяалагдах жоу, сяний данс бүртгэлд хамрагдаж, өртөөний цэргийн овог нэр болон хүлээн авч дамжуулсан бичиг баримтын цаг хугацааг тэмдэглэх ёстой бөгөөд тухайн өртөөний цэрэг албан бичгийг дараагийн өртөөнд хүргээд буцаж ирсний дараа гардуулан өгсөн цаг хугацааг дахин тэмдэглэдэг байжээ. Өртөөний цэрэг өдөр шөнө ээлжлэн харуулд гарах бөгөөд шөнийн цагаар өртөө бүхэн “Тасралтгүй гэрэлтэх дэнлүү” асаадаг байв. Ихэнх бичиг баримтыг хавтаслан зөөлөн бөс торгоор ороон гадуур нь тостой бөсөөр дахин баглан боогоод өртөөний цэрэг ногоон тос, шар үсэгтэй пайз барин цааш хүргэнэ. Алс хол хязгаар нутагт хүргэх бичиг баримтыг хайрцагт хийн битүүмжлээд дээр нь ямар нэг үсэг, илгээсэн хугацааг бичиж тэмдэглээд, алдаатай эсэхийг тулгаж үзнэ. Хайрцаг дээр хар тос, улаан үсгээр бичгийн дугаарыг тавьж ялгана. Өртөө бүхэнд яаралтай бичгийг хүлээн авсны дараа илгээсэн цаг хугацааг шалгах төдийгүй тухайн бичиг задарсан

эсэхийг нарийвчлан шалгадаг байжээ (史卫民, 中国军事通史. 第十四卷-元代军事史 1998, 第373 页). Албан ёсоор өртөөний цэргийн бүртгэлд орсон бол “Тухайн өрхийн идэр насны залуу өөрийн биеэр алба хаах” ба өөр хүнийг өөрийнхөө оронд алба хаалгаж болдоггүй байв. Шуурхай өртөөний тухай сурвалжид “Өртөөний цэрэг бүхэн дүүжин хонх, богино буу, борооны цувтай байна. Өртөөний цэрэг бичиг баримтыг аван замд явж байхдаа хонхоо дуугаргавал зөрөн өнгөрөгсөд зам тавьж өгнө. Замын турш хонх дуугарсаар дараагийн өртөөнд хүрэхэд өртөөний хүмүүс угтан ирж бичиг баримтыг хүлээн авна. Өртөөнөөс өртөөний хооронд өдөр шөнө ялгалгүй урагшилж, салхи, бороог ажралгүй явах ба тогтоосон ёсоор өртөө нь яаралтай бичиг баримтыг хоногт 400 ли газар явж хүргэх ёстой байв. Шуурхай өртөө бичиг баримтыг баталгаатай дамжуулж байгааг батлахын тулд чөлгөө бүрийн ерөнхийлөн захирах хорооны цалинтай түшмэл улирал бүр өөрийн биеэр явж сануулга өгдөг байсан” (宋濂. 赵坝. 王祎 1976) гэжээ.

Дүгнэлт

Хүннүгийн үеэс улбаатай зам харилцааны энэ уламжлалыг хожмын нүүдэлчдийн төр улсууд залган авч хөгжүүлснээр Их Монгол улсын үе хүрсэн бөгөөд Юань улсын үед өртөөний тогтолцоо улам бүр боловсронгуй болж, цэцэглэн хөгжсөн байна.

Юань улсын өртөөний замууд нь улс орныг бүрэн хэрэн сүлжсэн байсан учир төв болон орон нутгийн харилцаа холбоог сайжруулан бататгасан төдийгүй аж ахуй, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны солилцоог хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болжээ. Юань улсын Хубилай хаан дөрвөн зүг, найман зовхисыг холбосон, хааны зарлигийг уламжилж буй элч, алба татвар хураагч, худалдаачин, цэргийнхэн, шашны лам хувраг нарын аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан, өндөр зохион байгуулалттай өртөөний тогтолцоог бий болгож чадсанаараа Монгол, Хятадын төдийгүй дэлхийн зам харилцааны хөгжилд асар их хувь нэмэр оруулсан юм.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Г.Алтансүх, Б.Амгаланбат, Т.Батбаяр, Г.Батболд, Б.Батцоож, Л.Ганбат, Л.Мөнхбаяр, et al. 2025. *Монголын эзэнт гүрэн. Их Юань улс ба Монгол дахь археологийн судалгаа*. УБ.
2. Г.Сүхбаатар, Л.Жамсран. 1968. *БНМАУ-ын түүхийн дээж бичиг*. УБ.
3. Ж.Базарсүрэн, Б.Батсүрэн, Ч.Дашдаваа, С.Цолмон, Ц.Энхчимэг. 2006. *Их монгол улсын зам харилцаа, өртөө*. УБ.
4. Т.Эрдэнэхишиг. 2008. *Хүннү, Хан улсын цэрэг, улс төрийн харилцаа*. УБ: Соёмбо.
5. Ч.Арьяасүрэн, Х.Нямбуу. 1992. *Монгол ёс заншлын их тайлбар толь. Тэргүүн боть*. УБ.
6. 1994. *中国丝绸之路辞典*. 新疆: 新疆人民出版社.
7. 1994. *中国丝绸之路辞典*. 新疆: 新疆人民出版社.
8. 史卫民. 1998. *中国军事通史. 第十四卷-元代军事史*. 北京: 军事科学出版社.
9. —. 1998. *中国军事通史. 第十四卷-元代军事史*. 北京: 军事科学出版社.
10. —. 1998. *中国军事通史第十四卷-元代军事史*. 北京: 军事科学出版社.
11. —. 1998. *中国军事通史第十四卷-元代军事史*. 北京: 军事科学出版社.
12. 宋濂. 赵坝. 王祎. 1976. *元史. 卷一〇一 <<兵志四. 急递铺*. 北京: 中华书局.
13. —. 1976. *元史. 志第四十九. 兵四*. 北京: 中华书局.
14. 宋濂. 赵坝., 王祎. 1976. *元史. 志第四十九. 兵四*. 北京: 中华书局.
15. 王祎, 宋濂. 赵坝. 1976. *元史. 志第四十九. 兵四*. 北京: 中华书局.